МОНГОЛ УЛСЫН
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙДЫН
ТУШААЛ

2026 оны 9 сарын 15 өдөр Дугаар А/176 Улаанбаатар хот

Эрсдэлийн үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт, хяналтын хуудас шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалт, Хүүхэд хамгаллын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолоор батлагдсан "Хяналт шалгалт хийх нийтлэг журам", Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2026 оны 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эрсдэл үнэлэх орчин, шалгуур үзүүлэлтийг нэгдүгээр, Эрсдэлийн үнэлгээ хийх хяналтын хуудас ашиглах зааврыг хоёрдугаар, Гэр бүлийн орчны эрсдэлийг үнэлэх хяналтын хуудсыг гуравдугаар, Боловсролын сургалтын орчны эрсдэлийг үнэлэх хяналтын хуудсыг дөрөвдүгээр, Эрүүл мэндийн үйлчилгээний орчны эрсдэлийг үнэлэх хяналтын хуудсыг тавдугаар, Хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчны эрсдэлийг үнэлэх хяналтын хуудсыг зургаадугаар, Хүүхдийн эрх, хамгаллын байгууллагын орчны эрсдэлийг үнэлэх хяналтын хуудсыг долоодугаар, Олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээний орчны эрсдэлийг үнэлэх хяналтын хуудсыг наймдугаар, Соёл, урлаг, спорт, үзвэр үйлчилгээний орчны эрсдэлийг үнэлэх хяналтын хуудсыг есдүгээр, Сүм хийд, шашны байгууллагын орчны эрсдэлийг үнэлэх хяналтын хуудсыг аравдугаар, Гамшиг, онцгой байдлын орчны эрсдэлийг үнэлэх хяналтын хуудсыг арван нэгдүгээр, Хууль сахиулах болон батлан хамгаалах салбарын орчны эрсдэлийг үнэлэх хяналтын хуудсыг арван хоёрдугаар, Амралт, сувилал, зочид буудал, саун массажны үйлчилгээний орчны эрсдэлийг үнэлэх хяналтын хуудсыг арван гуравдугаар, Аж үйлдвэр, барилга, үйлдвэрлэлийн орчны эрсдэлийг үнэлэх хяналтын хуудсыг арван дөрөвдүгээр, Санхүү, эдийн засаг болон бусад төрийн байгууллагын орчны эрсдэлийг үнэлэх хяналтын хуудсыг арван тавдугаар, Байгаль орчин, аялал, жуулчлалын салбарын орчны эрсдэлийг үнэлэх хяналтын хуудсыг арван зургаадугаар, Зам тээвэр, авто замын байгууллагын орчны эрсдэлийг үнэлэх хяналтын хуудсыг арван долоодугаар, Уул уурхай, олборлолт, үйлдвэрийн орчны эрсдэлийг үнэлэх хяналтын хуудсыг арван наймдугаар, Хоол үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний байгууллагын орчны эрсдэлийг үнэлэх хяналтын хуудсыг арван есдүгээр, Хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарын орчны эрсдэлийг үнэлэх хяналтын хуудсыг хорьдугаар, Хог хаягдал, боловсруулах үйлдвэрийн орчны эрсдэлийг үнэлэх хяналтын хуудсыг хорин нэгдүгээр, Цахилгаан,

эрчим хүчний салбарын орчны эрсдэлийг үнэлэх хяналтын хуудсыг хорин хоёрдугаар, Усан бассейн, цэцэрлэгт хүрээлэн, тоглоомын талбайн орчны эрсдэлийг үнэлэх хяналтын хуудсыг хорин гуравдугаар, Гудамж, зам, нийтийн эзэмшлийн талбайн орчны эрсдэлийг үнэлэх хяналтын хуудсыг хорин дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг бүх, яам, агентлаг, бүх шатны Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллагад даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гэр бүлийн бодлогын газрын дарга (Д.Мөнгөнтуул), Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Мөнхзул/ нарт үүрэг болгосугай.

4.Энэ тушаал батлагдсантай холбоотойгоор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2026 оны “Эрсдэлийн үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт батлах тухай” А/143 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

САЙД Т.АУБАКИР

D: 2026 on 09 sar A4

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгаалллын сайдын 2026 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн А/176 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Он.....

А.Хаягийн хэсэг

Аймаг, нийслэлийн нэр, код .....

Сум, дүүргийн нэр, код .....

Байгууллагын нэр, РД .....

ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, эрсдлийн орчин, төрөл, шийдвэрлэлтээр

Б.Үндсэн мэдээлэл

ЭРСДЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	МД	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлтийн төрлөөр															
		Бүгд	Арилгасан	Үргэлжилж байгаа	Шийдвэрлэээгүй	Нүх, суваг, шуудуу, нурангид унах, гацах, гэмтэх, цохигдох аюул				Цахилгаан, өндөр хүчдэл, ил утас, монтажны гэмтэл, цахилгаанд цохиулах, шаталт				Зам, зорчих хөдөлгөөн, автомашин, мотоцикл, дугуй, нийтийн тээврийн осол				Галын аюул, шатах материал, газ, галын хэрэгсэл			
						Бүгд	Арилгасан	Үргэлжилж байгаа	Шийдвэрлэээгүй	Бүгд	Арилгасан	Үргэлжилж байгаа	Шийдвэрлэээгүй	Бүгд	Арилгасан	Үргэлжилж байгаа	Шийдвэрлэээгүй	Бүгд	Арилгасан	Үргэлжилж байгаа	Шийдвэрлэээгүй
А	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20
Бүгд мөр (1)= мөр (2÷24)	1																				
Гэр бүлийн орчин	2																				
Боловсролын сургалтын байгууллагын орчин	3																				
Эрүүл мэндийн үйлчилгээний орчин	4																				
Хэвлэл, мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчин	5																				
Хүүхдийн эрх, хамгаалллын үйлчилгээний орчин	6																				
Олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээний орчин	7																				
Соёл, урлаг, спорт, үзвэр үйлчилгээний орчин	8																				
Сүм хийд, шашны байгууллагын орчин	9																				
Гамшиг, онцгой байдлын орчин	10																				
Хууль сахиулах байгууллагын орчин	11																				
Амралт, сувилал, зочид буудал, саун массажны үйлчилгээний орчин	12																				
Аж үйлдвэр, барилга, үйлдвэрлэлийн орчин	13																				
Батлан хамгаалах салбарын орчин	14																				
Байгаль орчин, аялал, жуулчлалын салбарын орчин	15																				
Зам тээвэр, авто замын байгууллагын орчин	16																				
Уул уурхайн олборлолт, үйлдвэрлэлийн орчин	17																				
Хоол үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний байгууллагын орчин	18																				
Хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарын орчин	19																				
Хог хаягдал, боловсруулах үйлдвэрлэлийн орчин	20																				
Цахилгаан, эрчим хүчний салбарын орчин	21																				
Усан бассейн, цэцэрлэгт хүрээлэн, тоглоомын талбайн орчин	22																				
Гудамж, зам, нийтийн зээмшлийн талбайн орчин	23																				
Бусад....	24																				

МД	Ус, гол, нуур, усан сан, усны хоолой, тогтоол усанд живэх аюул				Химийн болон хорт бодис, цэвэрлэгээний бодис, эмийн бүруу хэрэглээ, хорт хийн эрсдэл				Цаг уур, байгалийн хүчтэй салхи, шуурга, аянга цахилгаан, хөлдөх эрсдэл				Барилга байгууламж барих, засварлах, нураах талбайн эрсдэл, хаалт хамгаалалт				Уул уурхайн олборлолт, нөхөн сэргээлт, хөрс нурах эрсдэл				Хөдөө аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн эрсдэл			
	Бүгд	Арилгасан	Үргэлжилж байгаа	Шийдвэрлээгүй	Бүгд	Арилгасан	Үргэлжилж байгаа	Шийдвэрлээгүй	Бүгд	Арилгасан	Үргэлжилж байгаа	Шийдвэрлээгүй	Бүгд	Арилгасан	Үргэлжилж байгаа	Шийдвэрлээгүй	Бүгд	Арилгасан	Үргэлжилж байгаа	Шийдвэрлээгүй	Бүгд	Арилгасан	Үргэлжилж байгаа	Шийдвэрлээгүй
Б	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	32	33	34	35	36	37	38	39	40	41	42	43	44
1																								
2																								
3																								
4																								
5																								
6																								
7																								
8																								
9																								
10																								
11																								
12																								
13																								
14																								
15																								
16																								
17																								
18																								
19																								
20																								
21																								
22																								
23																								
24																								

МД	Хог хаягдал, шатаах боловсруулах үйлдвэрлэлийн эрсдэл				Төглоомын талбайн эвдрэл, төхөөрөмжийн аюул, унах, цохигдох, дарагдах эрсдэл				Гэрийн орчинд өндрөөс унах, ахуйн осол, хахалт, түлэгдэх эрсдэл				Цахим орчны зохисгүй хэрэглээ, цахим дарамт, мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл				Энтертаймент салбар, хэт чанга дуу, хурц гэрэл, хүүхдийн сэтгэл санаа, эрүүл мэндэд нөлөөлөх эрсдэл				Амьтан, шавьжид хатгуулах, хазуулах эрсдэл			
	Бүгд	Арилгасан	Үргэлжилж байгаа	Шийдвэрлээгүй	Бүгд	Арилгасан	Үргэлжилж байгаа	Шийдвэрлээгүй	Бүгд	Арилгасан	Үргэлжилж байгаа	Шийдвэрлээгүй	Бүгд	Арилгасан	Үргэлжилж байгаа	Шийдвэрлээгүй	Бүгд	Арилгасан	Үргэлжилж байгаа	Шийдвэрлээгүй	Бүгд	Арилгасан	Үргэлжилж байгаа	Шийдвэрлээгүй
Б	45	46	47	48	49	50	51	52	53	54	55	56	57	58	59	60	61	62	63	64	65	66	67	68
1																								
2																								
3																								
4																								
5																								
6																								
7																								
8																								
9																								
10																								
11																								
12																								
13																								
14																								
15																								
16																								
17																								
18																								
19																								
20																								
21																								
22																								
23																								
24																								

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2026 оны 9.. дугаар сарын 15-ны өдрийн А/176 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ
ХЯНАЛТЫН ХУУДАС АШИГЛАХ ЗААВАР

Нэг. Зорилго, хамрах хүрээ

1.1.Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2026 оны 03 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд бүр "Эрсдэлийн үнэлгээ хийх хяналтын хуудас" ашиглан гэр бүлийн орчин болон хуулийн этгээдийн[1] (байгууллага) гадна дотно орчны эрсдэлийг үнэлэх, шалгалт зохион байгуулах, болзошгүй аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөрчил дутагдлыг илрүүлэх, арилгах, хүүхдийн эрүүл аюулгүй, таатай орчинд амьдрах, сурч, боловсрох нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2026 оны "Тогтоол батлах тухай" 03 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Хүүхдийн төлөө За бол заавал хийе" үндэсний хөдөлгөөний удирдамжийн 3.2.1.1, 3.2.1.2, 3.2.1.3, 3.2.1.4, 3.2.1.5, 3.2.1.6, 3.2.1.7, 3.3.1.3 дахь арга хэмжээний хүрээнд хуулийн этгээд бүр гадаад, дотоод орчны эрсдэл, хүүхэд хамгааллын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэхэд хяналтын хуудсыг ашиглана.

Хоёр.Эрсдэлийн үнэлгээ хийх, удирдлага зохион байгуулалт

2.1.Энэхүү зааврыг байгууллагын удирдах албан тушаалтан, дотоод хяналтын ажилтнууд, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх эрх бүхий албан тушаалтан, нийгмийн ажилтан, улсын байцаагч нь тухайн байгууллагад гадаад, дотоод орчны эрсдэлийн үнэлгээ, хүүхэд хамгааллын эрсдэлийг үнэлэхэд ашиглана.

2.2. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3-т заасны дагуу эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь гэр бүлийн орчны эрсдэлээ үнэлэхдээ энэхүү тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан "Гэр бүлийн орчны эрсдэлийг үнэлэх хяналтын хуудас"-ыг ашиглана.

2.3.Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдийн гэр бүлийн орчинд Хамтарсан багийн гишүүн болох хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, халамжийн нийгмийн ажилтан, өрхийн эмч гэр бүлийн орчны эрсдэлийн үнэлгээг хийнэ. Үнэлгээгээр дунд болон их эрсдэлтэй байвал Хүүхэд хамгааллын тухай хуулийн хоёрдугаар бүлэгт заасан хүүхэд хамгааллын үйлчилгээг төлөвлөн хэрэгжүүлнэ.

2.4.Байгууллагын орчинд хүүхдийн эрх, аюулгүй байдалд учирч болзошгүй аюул, эрсдэлийг илрүүлж, хор уршгийг арилгах, хяналт тавих үүрэг бүхий 3-5 хүний

[1] Өмчийн хэлбэр харгалзахгүй үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгжийг ойлгоно.

бүрэлдэхүүнтэй “Эрсдэлийн хяналтын хороо” (цаашид “Хяналтын хороо” гэх)-ийг байгуулж ажиллана. Уг хяналтын хороо нь урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж эрсдэлийг арилгах, гүйцэтгэлийн хяналт тавих үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлнэ.

2.5.Эрсдэлийн хяналтын хороо нь дараах бүрэлдэхүүнтэй байна.

2.5.1.Эрсдэлийн хорооны дарга: Байгууллагын газар/нэгжийн дарга, эсхүл захирал, газар/нэгжийн бүтэцгүй байгууллагад “Эцэг эхийн зөвлөл”-ийн дарга;

2.5.2.Нарийн бичгийн дарга:Дотоод хяналт хариуцсан албан тушаалтан;

2.5.3.Гишүүд: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан, хууль эрх зүй, нийгмийн хамгаалал, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чиг үүрэг гүйцэтгэдэг мэргэжилтэн, байгууллагын Эцэг, эхийн зөвлөлийн төлөөлөл.

2.6.Эрсдэлийн хяналтын хорооны дарга, гишүүдийн эрх, үүрэг:

2.6.1.Эрсдэлийн хяналтын хорооны дарын чиг үүрэг:

- Эрсдэлийн хяналтын хорооны удирдамж батална;
- Гишүүдийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, төлөвлөгөө баталж, хэрэгжилтэд хяналт тавих;
- Гадаад, дотоод орчинд илэрсэн эрсдэлийг шуурхай арилгасан талаарх шийдвэрийг баталгаажуулах;
- Ажлын хэсгийн гишүүдэд хяналтын хуудсыг хэрхэн бөглөх талаар заавар, зөвлөгөө өгөх;
- Хувь хүний нууцтай холбоотой мэдээллийн нууцлалыг хамгаалах зорилгоор гишүүдээр “нууцын баталгаа” гаргуулна.
- Эрсдэл их болон дунд эрсдэлтэй үнэлэгдсэн бол мэргэжлийн байгууллага, эсхүл салбарын хяналтын улсын байцаагчид шуурхай мэдээлж, холбогдох арга хэмжээг авна.

2.6.2. Эрсдэлийн хяналтын хорооны гишүүд:

- Байгууллагын гадна болон дотоод орчны үзлэг хийх, эрсдэлийг хяналтын хуудсаар үнэлэх, зөрчлийг зургаар баталгаажуулж, эрсдэл бүртгэх Саадгүй, хүртээмжийн систем (heatmap.longbinarycity.com)-д оруулах;

- Илэрсэн зөрчлийн талаарх мэдээллийг “Хяналтын хороо”-ны даргад танилцуулж, зөрчлийг арилгах арга хэмжээг нэн даруй авч, үр дүнг зургаар баталгаажуулна.

Жишээ нь: Хяналтын хороо цахилгааны ил утас гарсан, разетка гэмтсэн зэрэг эрсдэл илрүүлсэн бол байгууллагын цахилгаан, сантехникийн ажилтнаар шалгуулж, засварлах, аюулыг арилгах арга хэмжээ авна.

- Эрсдэл их болон дунд эрсдэлтэй үнэлэгдсэн бол байгууллагын “Хяналтын хороо”-ны даргад шуурхай мэдээлж, холбогдох арга хэмжээг авахуулна.

2.6.3. Нарийн бичгийн дарга:

- Эрсдэлийн хяналтын хорооны хурал зохион байгуулах, төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан нэгтгэх, илрүүлж, арилгасан эрсдэл, зөрчлийн мэдээллийг олон нийтэд мэдээлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулна.

2.7. Хүүхдийн эрх хамгаалал, боловсрол, эрүүл мэнд, соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбар нь орчны эрсдэлээ үнэлэхдээ эцэг, эх, асран хамгаалагч, хүүхэд, сайн дурын ажилтантай хамтран ажиллана.

2.8. Олон нийтийн арга хэмжээ үйлчилгээ, амралт, сувилал, зочид буудал, саун массажны үйлчилгээний орчин, усан бассейн, цэцэрлэгт хүрээлэн, тоглоомын талбай, гудамж, зам, нийтийн эзэмшлийн талбайн орчны эрсдэлийг үнэлэхдээ иргэд олон нийт, сайн дурын ажилтан, хэсгийн ахлагч, Сууц өмчлөгчдийн холбоо зэрэг олон нийтийн санаачилга, оролцоог хангаж ажиллана.

2.9.Эрсдэлийг илрүүлэх, үнэлгээ хийх үйл ажиллагааг дараах үе шаттайгаар явуулна.

а/Бэлтгэл үе шат:

- Салбарын болон байгууллагын гадаад, дотоод орчны эрсдэл үнэлэх обьектыг тодорхойлсон байна.
- Байгууллагын нийт албан хаагчдад үнэлгээ хийх талаар мэдээллийг хүргүүлсэн байна.
- Хяналтын хорооны гишүүд болон Эцэг эхийн зөвлөл, эцэг эх, олон нийт, хүүхдэд хяналтын хуудас бөглөх, эрсдэл бүртгэх Саадгүй, хүртээмжийн систем (heatmap.longbinarycity.com)-д хэрхэн бүртгэх заавар өгнө.
- Эрсдэл үнэлэлэх заавар, хяналтын хуудсыг байгууллагын сайтад байршуулна.

б/ Эрсдэлийн үнэлгээ хийх үе шат:

- **Гадаад, дотоод орчны эрсдэлийн үнэлгээ**: Гадна талбайн орчин дахь орц, гарц, зам, талбай, тоглоомын талбай, спортын талбай, гэрэлтүүлэг, цахилгааны аюулгүй байдал, далан, суваг, шуудуу, анхааруулах дохио санамж, хаалт, хамгаалалт, нүх цооног, хашаа, саравч, ариун цэврийн байгууламж, камержуулалтыг хяналтын хуудсаар үнэлж, зөрчлийг зургаар баталгаажуулж, эрсдэл бүртгэх цэст байршуулна.
- **Байгууллагын дотоод орчны эрсдэлийн үнэлгээ**: Урлаг, спортын заал, бассейн, сургалт, уулзалтын танхим, хүүхэд хөхүүлэх өрөө, хүлээлгийн танхим, гал тогоо, хоолны заал, ариун цэврийн болон хүүхэд усанд орох өрөө, номын сан зэргийн камержуулалт, цахилгааны аюулгүй байдал, галын аюулгүй байдал, шат, ирмэгтэй хурц зүйл, гарц, хонгилын хэсэг, цонхны хаалт, хамгаалалт, эрүүл ахуй, халдвар хамгааллын бэлэн байдлыг хяналтын хуудсаар үнэлж, зөрчлийг зургаар баталгаажуулж, эрсдэл бүртгэх цэст байршуулна.
- **Цахим орчны эрсдэлийн үнэлгээ**: Байгууллагын Wi-Fi сүлжээний шүүлтүүр, хяналтын горимыг идэвхжүүлсэн эсэхтэй танилцана. Нийгмийн сүлжээн дэх хүүхдэд учирч болзошгүй эрсдэлийг илрүүлж, урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө, явцыг шалгана.

- **Хүүхэд хамгааллын эрсдэлийг үнэлэх:** “Эрсдэлийн үнэлгээ хийх хяналтын хуудасны **“В.Хүүхэд хамгааллын эрсдэл”** хэсгийн асуумжийг ашиглана. Хяналтын хуудасны асуумжийг (цахимаар, цаасаар) бөглөхдөө баримт бичигтэй танилцах, уулзалт хийх, санал сонсох, ажиглалт хийх зэрэг аргуудаас аль тохирох аргыг сонгоно.

- Баримт бичигтэй танилцах: Байгууллагын хүүхэд хамгааллын бодлого, дүрэм, холбогдох зааврын мөрдөлт, хөдөлмөрийн дотоод журам, хамтын ажиллагааны гэрээнд тусгасан эсэхийг шалгана.
- Хяналтын хороо нь хүүхдэд шууд үйлчилгээ үзүүлдэггүй бол байгууллагын Эцэг эхийн зөвлөл, албан хаагчдын төлөөлөлтэй уулзалт хийх;
- Хүүхдэд үйлчилгээ үзүүлдэг боловсрол, эрүүл мэнд, хүүхэд, гэр бүлийн, соёл, урлаг, спортын салбарын байгууллага дээр хүүхэдтэй ажиллаж байгаа мэргэжилтэн, багш, сурган хүмүүжүүлэгч, дасгалжуулагч, эцэг, эх, асран хамгаалагчийн төлөөлөлтэй уулзалт хийх;
- Боловсрол, сургалт, хүүхдийн эрх, хамгаалал, соёл, урлаг, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага дээр хүүхдийн нас сэтгэхүйд тохирсон арга хэлбэрийг сонгон хүүхдүүдтэй уулзалт хийж, санал сонсож болно.
- Амралт, сувилал, аялал жуулчлал, зочид буудал, худалдаа үйлчилгээний газар, усан бассейн зэрэг олон нийтийн үйлчилгээний байгууллагын “Хяналтын хороо” байгууллагын Эцэг эхийн зөвлөл, эсхүл байгууллагын ажилтнуудтай уулзалт хийх, үйлчлүүлэгчдээр асуумж бөглүүлэх зэргээр олон арга ашиглаж болно.

Гурав.Хяналтын хуудас ашиглах

3.1.Хяналтын хуудас нь Ерөнхий мэдээлэл, Орчны аюулгүй байдлын эрсдэл, Хүүхэд хамгааллын эрсдэл, Арга хэмжээний биелэлт, баталгаажуулалт гэсэн бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдэнэ.

3.2.Хуулийн этгээд, иргэд, олон нийтийн төлөөлөл нь өөрийн байгууллагын үйл ажиллагаа, салбарын чиг үүрэгт тохирох хяналтын хуудсыг сонгон хэрэглэнэ.

Жишээ нь:Хүүхдийн зуслан, ордон, өдөр өнжүүлэх төв, хүүхэд харах үйлчилгээний төв зэрэг хүүхдэд үйлчилгээ үзүүлдэг хуулийн этгээд “Хүүхдийн эрх, хамгааллын байгууллагын орчны эрсдэлийг үнэлэх хяналтын хуудас”-ыг ашиглана.

3.3.Хяналтын хуудасны асуумж нь байгууллагын гадаад болон дотоод орчноос шалтгаалж хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал, нийгмийн болон хүрээлэн байгаа орчны аюулгүй байдалд сөрөг нөлөөлөл учирч болзошгүй асуудалд чиглэсэн байна. Түүнчлэн шаардлага хангасан эсэхийг тодорхойлох, зөрчлийг тэмдэглэх, тайлбар хэсэгтэй байна. Илрүүлсэн орчны эрсдэлийн зургийг эрсдэл бүртгэх цахим системд оруулна.

3.4."Эрсдэлийн үнэлгээ хийх хяналтын хуудас”-аар эрсдэлийг үнэлэхдээ хяналтын хуудасны бүрэлдэхүүн хэсгүүдийг дараах байдлаар бөглөнө:

“А.Ерөнхий мэдээлэл”:Энэ хэсэгт хуулийн этгээдийн нэр, хаяг байршил, хугацаа, үйл ажиллагааны чиглэл, эрсдэлийн хяналтын хуудас бөглөсөн хугацааны талаарх мэдээллийг товч тодорхой бөглөнө.

“Б.Орчны аюулгүй байдлын эрсдэл”-ийг тухайн байгууллагын “Хяналтын хороо”-ны гишүүд, эцэг эх, асран хамгаалагч, хувь хүн, хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлдэг тухайн салбарын хяналтын улсын байцаагч нар үнэлнэ.

“В.Хүүхэд хамгааллын эрсдэл”-ийг Хяналтын хорооны гишүүн, хүүхдэд үйлчилгээ үзүүлдэг нийгмийн ажилтан, сэтгэл зүйч болон байгууллагын “Эцэг эхийн зөвлөл”-ийн төлөөлөл, хүүхдийн эрхийн улсын байцаагч нар үнэлнэ.

“Г.Арга хэмжээний биелэлт, баталгаажуулалт”

3.5.Дараах аргачлалын дагуу бөглөнө:

а/Хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлэхдээ асуултын дарааллын дагуу бодит байдлыг газар дээр нь нухацтай шалгаж, зөрчлийг гэрэл зургаар баталгаажуулна. Асуулт тус бүрийн ард "Тийм" (1-Зөрчилтэй/эрсдэлтэй), "Үгүй" (0-Эрсдэлгүй) гэж тэмдэглэнэ. Харин тухайн шалгуулагч этгээдэд хамаарахгүй тохиолдолд харгалзах хэсэгт чагт тэмдгийг тавьж хяналтын хуудасны нийт асуултаас хамаарахгүй хэсгийн асуултын оноог хасаж хувийг тооцно.

б/Шаардлага хангасан эсэхийг тийм, үгүй гэсэн хариултаар үнэлэх ба “Тийм” гэсэн хариулт нь хангалтгүй, байхгүй, нийцэхгүй байна гэсэн утгыг илэрхийлнэ. “Үгүй” гэсэн хариулт нь тийм, байна, нийцэж байна, хангалттай гэсэн утгыг илэрхийлнэ.

в/Хяналтын хуудасны асуулт бүрт батлагдсан онооноос өөр оноог өгөхгүй.

г/Хяналтын хуудасны асуултуудыг бөглөж дууссаны дараа байгууллагын гадаад болон дотоод орчин, үйлдвэрлэлийн талбай, үзүүлж байгаа ажил, үйлчилгээ нь хүүхдэд ээлтэй, аюул эрсдэлгүй орчныг бүрдүүлж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа эсэхээс шалтгаалан эрсдэлийг бага, дунд, их түвшинд ангилна. Тухайлбал:

Нийт асуултын 50 ба түүнээс дээш хувьд "Тийм" (1-Зөрчилтэй/Эрсдэлтэй) гэж хариулсан бол их эрсдэлтэй гэж дүгнэнэ. (“Их эрсдэл >=50%);

Нийт асуултын 30-49 хүртэлх хувьд "Тийм" (1-Зөрчилтэй/Эрсдэлтэй) гэж хариулсан бол дунд эрсдэлтэй гэж дүгнэнэ. (Дунд эрсдэлтэй [30%-49%])

Нийт асуултын 29 хувьд "Тийм" (1-Зөрчилтэй/Эрсдэлтэй) гэж хариулсан бол бага эрсдэлтэй гэж дүгнэнэ.(Бага эрсдэлтэй <=29%).

Жишээ:Байгууллагын гадаад, дотоод орчны эрсдэлийг 19 асуултаар үнэлэхэд 10 асуултад “Тийм” (1-Зөрчилтэй/Эрсдэлтэй) гэж үнэлэгдсэн бол дундаж оноо 52.6% буюу “Их эрсдэлтэй” гэж үнэлэгдэнэ.

$$\text{Эрсдэлийн түвшин (52.6\%)} = \frac{\text{Нийт хариулт 10 буюу (тийм)} \times 100\%}{\text{Нийт асуумж (19)}}$$

д/Хяналтын хуудсаар “дунд” болон “их эрсдэлтэй” гэж дүгнэсэн бол тухайн зөрчил/эрсдэлийг нэн даруй арилгах арга хэмжээг авч, өөрсдийн ажил үүрэгт хамаарах чиглэл бүрийн хяналтын улсын байцаагч нарт шилжүүлэн хяналт, шалгалтыг зохион байгуулна. *Жишээ нь:*

- *Хүүхдийн амь нас, эрүүл мэндэд шууд хор хохирол учруулж болзошгүй зөрчил (ил гарсан өндөр хүчдэлийн утас, бөглөөгүй нүх, цооног, траншей, халдварт өвчин тархах эрсдэл, хоолны хордлого г.м);*
- *Хяналтын хуудасны (B) Хүүхэд хамгааллын эрсдэлийн аль нэг нь (хүүхдийн эсрэг хүчирхийлэл, заналхийлэл, цахим орчны бэлгийн мөлжлөг гэх мэт) илэрсэн эсхүл сэжиг таамаг байгаа бол эрсдэлтэй гэж үзэн байгууллагын Хүүхэд хамгааллын бодлогын дагуу мэргэжлийн байгууллага, хүүхдийн эрхийн улсын байцаагч, нийгмийн ажилтанд нэн даруй мэдээлж, холбон зуучлах арга хэмжээг авна.*

Улсын байцаагч хяналт шалгалтыг зохион байгуулахдаа Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Хяналт шалгалт хийх нийтлэг журмын дагуу зохион байгуулна. Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгасан эсэхийг зургаар баталгаажуулж, эрсдэл бүртгэх цэст оруулж, шийдвэрлэлтийг тэмдэглэнэ.

е/Хяналт, шалгалтын хуудасны асуумжийн дундаж оноо “дунд” болон “их эрсдэлтэй” гэж үнэлэгдвэл тухайн эрсдэлийг арилгах арга хэмжээг тухайн байгууллага нэн даруй авах үүрэг хүлээнэ.

ё/Бага эрсдэлтэй гэж үнэлэгдсэн бол 1-3 хоногт, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн бол 7 хоногт, их эрсдэлтэй гэж үнэлэгдсэн бол 30 хоногт багтаан шийдвэрлэж, баталгаажуулна.

з/Хяналтын хуудсаар бага эрсдэлтэй үнэлэгдсэн боловч засах шаардлагатай, хүүхдийн амь нас, эрүүл мэндэд учруулж болзошгүй зөрчлийг арилгуулахаар цагдаа, онцгой байдал, цахилгаан эрчим, хүч, эрүүл мэнд, эрүүл ахуйн болон бусад мэргэжлийн байгууллагад нэн даруй мэдэгдэж, шийдвэрлүүлнэ.

Жишээ нь: Хүүхдийн амь нас, эрүүл мэндэд шууд хор хохирол учруулж болзошгүй зөрчил, ил гарсан өндөр хүчдэлийн утас, бөглөөгүй нүх, цооног, траншей, халдварт өвчин тархах эрсдэл, хоолны хордлого гэх мэт.

Дөрөв. Эрсдэлийн үнэлгээний нэгдсэн тайлан гаргах:

4.1.Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2026 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн “Эрсдэлийн үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт, хяналтын хуудас батлах тухай” А/176 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Эрсдэлийн үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт (эрсдэлийн орчин, төрлөөр)-ийн дагуу тайлан гаргана.

4.2.Эрсдэлийн үйлчилгээний нэгдсэн тайлан, мэдээллийг Засгийн газрын Их өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих систем (dashboard.gov.mn)-ээр дамжуулан шийдвэр гаргагч, бодлого боловсруулагч нарт хүргэнэ.

4.3.Саадгүй, хүртээмжийн систем (heatmap.longbinarycity.com)-ээр дамжуулан иргэд, олон нийтэд нээлттэй байршуулна.

4.4.Эрсдэл илрүүлж, арилгасан баталгаажуулалтыг:

а/ Байгууллагын Эрсдэлийн хяналтын хорооны дарга;

б/ Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан;

б/ Дундаас дээш эрсдэлтэй гэж дүгнэн салбарын хяналтын байцаагч шалгаж, арилгасан эрсдэл/зөрчлийн баталгаажуулалтыг “Улсын байцаагч” гүйцэтгэнэ.

Тав. Санамж, анхаарах зүйл

5.1.Байгууллага нь аливаа үйл ажиллагаанд хүүхдийг хүчирхийлэл, мөлжлөг, үл хайхрах байдалд оруулж болзошгүй нөхцөл байдлаас урьдчилан сэргийлж, эрсдэлийг бууруулах, учирч болзошгүй хор нөлөө, сөрөг үр дагаварыг багасгах, арилгахад байнга анхаарч ажиллана.

5.2.Боловсрол, эрүүл мэнд, хүүхдийн эрх, хамгаалал, соёл, спорт, урлагийн болон сүм, хийдийн байгууллагын сургалт, үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхэдтэй зөвхөн мэргэжлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, багш, сурган хүмүүжүүлэгч, хүүхдийн эрхийн улсын байцаагч уулзалт, ярилцлага хийнэ.

5.3. Хүүхдийн суралцаж, амьдарч, үйлчилгээ авч байгаа орчны эрсдэлийг үнэлэх, хүүхдүүдтэй уулзаж харилцах ажилтан, эцэг, эх, хүүхэд, олон нийт, сайн дурын ажилтанд хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, хүний хувийн мэдээллийг хамгаалах, нууцлах, холбон зуучлах, хүүхэдтэй зүй бус харилцахаас урьдчилан сэргийлэх агуулгаар сургалт, мэдээллийг заавал хийнэ.

5.4.Байгууллага дээр хүүхэд эрсдэлт нөхцөлд өртсөн талаар мэдсэн, ажигласан, таамагласан бол Хүүхдийн тусламжийн 108 утсанд заавал мэдээлж, холбон зуучилна.

5.5.Хүүхдийг мэргэжлийн байгууллагын үйлчилгээнд холбон зуучлахдаа хүүхдийн хувийн нууцыг задруулахгүй байх, хүүхдэд айдас, түгшүүр үүсгэхгүй байх нөхцөлийг бүрдүүлж ажиллана.

5.6.Хяналтын хорооны гишүүд, эцэг, эх, асран хамгаалагч, хүүхэд, иргэд олон нийт хоолны хордого гарах эрсдэл, ундны усны чанар, халдвар тархах эрсдэлийг үнэлэхдээ дараах ажиглалтыг хийж, эрсдэлтэй эсэхийг үнэн зөвөөр тэмдэглэнэ.

а/Хоолны хордлого гарах эрсдэлийг ажиглалтаар таних:

- Хоол бэлтгэж буй орчин, тогоочийн гар, багаж хэрэгсэл бохир, ажилтнууд амны хаалт, бээлий хэрэглэхгүй байх;
- Хоолны бэлтгэлийн хэрэгслийг дутуу угааж, ариутгах;
- Түүхий мах хэрчсэн гамбанз, хутгаараа шууд бэлэн болох хүнсийг (*салат, жимс г.м*) хэрчих;
- Хоолны боловсруулалт дутуу, эсхүл хоол цайрах, гашилсан, хөгцөрсөн эвгүй үнэр гарах, өнгө хувирах (*мах сааралтах эсвэл ногоорох*);
- Мах, өндөг, далайн гаралтай бүтээгдэхүүнийг гүйцэд чанаж, шарж боловсруулаагүй байх;
- Хоолны амт нь гашуун, исгэлэн эсхүл ерөнхийдөө өөрчлөгдсөн;
- Хоолны дээж авч хадгалаагүй байх;
- Түүхий болон бэлэн бүтээгдэхүүнийг хамт хадгалах;
- Түргэн муудах бүтээгдэхүүн (мах, сүү, өндөг, майонезтай салат г.м)-ийг хөргөгчгүй орчинд буюу зохих дулааны горимд хадгалаагүй байх;

- Лаазалсан болон хайрцагласан хүнсний сав, баглаа боодол цоорсон, цүлхийсэн, дарагдсан, лац нь задарсан;
- Хадгалах болон хэрэглэж дуусах хугацаа дууссан зэрэг шинж тэмдэг ажиглагдвал хоолны эрүүл ахуй ба бэлтгэх, боловсруулах, хадгалах үйл явц алдагдсан, хордлого гарах эрсдэлтэй гэж үзнэ.

б/Ундны усны чанарыг ажиглалтаар таних:

Ундны ус бохирдсон эсвэл чанаргүй байгааг мэргэжлийн лабораторийн шинжилгээнээс гадна энгийн мэдрэхүйн ажиглалтаар (харагдах байдал, үнэр, амт) дараах байдлаар таньж болно:

- Усны өнгө *(шар, хүрэн, улаан, цайвар, цагаан, цэнхэр эсхүл ногоон өнгөтэй)*, тунгалаг чанар өөрчлөгдөж, булагдсан эсвэл булингартай байх:
- Ус сүүмгэр, шаварлаг эсвэл хөвөгч биеттэй байвал хөрсний бохирдол, элс, замаг эсвэл шугам сүлжээний зэв орсон байх эрсдэлтэй.
- Өндөг муудсан мэт үнэртэй *(хүхэрт устөрөгч)*;
- Шороо, хөгц ихтэй;
- Ахуйн эсвэл үйлдвэрийн химийн бохирдол, тос шатахуун түгээх газартай ойр;
- Химийн бодис, шатахуун, метал, давс болон гашуун амттай;
- Ундны усны эх үүсвэр, худаг, усан сангийн ойролцоо бохир ус, хог хаягдал цугларах, шугам сүлжээ задарч хөрсний бохирдолд орох.

в/<u>Халдвар тархах эрсдэлийг таньж илрүүлэх:</u>

Нийгэм, олон нийтийн дунд халдварт өвчин тархах эрсдэлтэй нөхцөл байдлыг дараах ажиглалтын шинжүүдээр таньж болно:


- Цонх, салхивч нээдэггүй, агааржуулалтын системгүй эсвэл хангалтгүй ажилладаг битүү орчинд (*ажлын байр, сургууль, цэцэрлэг, хүүхдийн үйлчилгээний орчин, олон нийтийн газар*) олон хүн цугларсан;
- Заал, үзвэрийн газар, худалдааны төв, нийтийн тээвэрт хүмүүс бие биетэйгээ ойрхон (1.5–2 метрээс дотогш) удаан хугацаагаар байх;
- Олон нийтийн хүрэлцдэг хаалганы бариул, шатны хашлага, лифтний товчлуур, цахилгаан шат, дэлгүүрийн тэрэг, бэлэн мөнгөний машин зэрэг олон хүн гараараа хүрдэг хэсгүүдийг ариутгаж цэвэрлээгүй;
- Олон нийтийн үйлчилгээний газарт гар угаах ус, саван, эсвэл гар ариутгагч бодис байхгүй;
- Нэг дор эсвэл нэг эх үүсвэрээс (*ундны усны худаг, хоолны газар г.м*) хэрэглэсэн ундны ус, хоол хүнсний бүтээгдэхүүнээс зэрэг олон хүн хордсон, эсхүл дотор муухайрах, бөөлжих, гэдэс базлах, суулгах, халуурах шинж илэрсэн;
- Сургууль, цэцэрлэг, байгууллага болон хороо, хотхоны хэмжээнд ижил төрлийн шинж тэмдэгтэй (*халуурах, ханиалгах, суулгах, бөөлжих*) хүмүүсийн тоо богино хугацаанд огцом нэмэгдсэн;
- Сургууль, цэцэрлэг, дотуур байр, эмнэлэг, хүүхдийн үйлчилгээний орчин зэрэгт агаар дуслын замаар халдварлах өвчний шинж тэмдэг илэрсэн;
- Халдварт өвчин туссан өвчтөнийг тусгаарлаагүй;
- Амьдарч, суралцаж байсан орчинд ариутгал, халдваргүйжүүлэлт хийгээгүй;

- Ахуйн ба эмнэлгийн хог хаягдлыг зориулалтын бус газар ил задгай хаях, хогийн сав дүүрч ил гарсан;
- Ялаа, жоом, хулгана зэрэг халдвар тээгч амьтад олон нийтийн байгууламж, хүнсний худалдааны газарт байгаа бол.

---oOo--

D: 2026 on 09 sar A4

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгаллын сайдын 2026 оны .9. дугаар сарын 15-ны өдрийн А/126 тоот тушаалын гуравдугаар хавсралт



ГЭР БҮЛИЙН ОРЧНЫ ЭРСДЭЛИЙГ ҮНЭЛЭХ ХЯНАЛТЫН ХУУДАС

А. Ерөнхий мэдээлэл

Иргэний нэр, РД: .....

Хаяг, байршил: .....

Огноо: .....

Б. Орчны аюулгүй байдлын эрсдэл

№	Үнэлэх шалгуур үзүүлэлт	**Тийм** *(1)*	**Үгүй** *(0)*	Илэрсэн эрсдэл/Тайлбар
1.	Гэрт хүүхэд өндрөөс унах эрсдэлтэй	[ ]	[ ]	
2.	Халуун ус, хоол, уурт түлэгдэх эрсдэлтэй	[ ]	[ ]	
3.	Хахах, амьсгалын зам бөглөрөх эрсдэлтэй жижиг эд зүйл, тоглоом, зайг ил хадгалсан	[ ]	[ ]	
4.	Хүүхэд хүрэх газарт хурц үзүүртэй хутга, хайч, зүү зэрэг зүйл байршуулсан	[ ]	[ ]	
5.	Гэр ахуйн цахилгаан хэрэгслийн аюулгүй байдал хангагдаагүй	[ ]	[ ]	
6.	Бага насын хүүхдийн гар хүрэх газарт аюултай бодис, эм, эмийн хэрэгсэл, эд зүйлс хадгалдаг	[ ]	[ ]	
7.	Зуух, яндангаас угаартах аюултай, угаар мэдрэгч ажиллуулдаггүй	[ ]	[ ]	
8.	Ус болон шингэн зүйл хадгалах савыг таггүй	[ ]	[ ]	
9.	Цонхны хаалт хамгаалалтгүй	[ ]	[ ]	
10.	Гэрийн дотоод/гадаад орчинд цахилгааны утас ил байрласан	[ ]	[ ]	
11.	Гэр/хашаандаа хог хаягдал цуглуулдаг	[ ]	[ ]	
12.	Суурин газарт хашаагүй, задгай амьдардаг	[ ]	[ ]	
13.	Үер усанд өртөх эрсдэлтэй орчинд амьдардаг	[ ]	[ ]	
14.	Голын эрэг, ой модтой ойрхон амьдардаг, амьтан шавьжид хатгуулах эрсдэлтэй	[ ]	[ ]	
15.	Авто замтай ойр байрладаг эсэх	[ ]	[ ]	
16.	00 болон бохир усны нүх ил задгай, хаалга, таггүй эсэх	[ ]	[ ]	
17.	Гэртээ буу, галт зэвсэг, хэрэгсэл ил хадгалдаг	[ ]	[ ]	

18.	Муур/нохой тэжээдэг	[ ]	[ ]	
19.	Амьдарч буй орчинд цахилгаан, цэвэр усны хангамж байхгүй	[ ]	[ ]	
	Дүн			

Эрсдэлийн үнэлгээ: [>=50%] Их, [30%-49%] Дунд, [<=29%] Бага эрсдэлтэй гэж үзнэ.

В. Хүүхэд хамгааллын эрсдэл

№	Үнэлэх шалгуур үзүүлэлт	**Тийм** *(1)*	**Үгүй** *(0)*	Илэрсэн эрсдэл/Тайлбар
1.	Эцэг, эх, асран хамгаалагч гэр бүлийн зөрчил, хүчирхийллийн харилцаатай	[ ]	[ ]	
2.	Хүүхэд хараа хяналтгүй үлддэг	[ ]	[ ]	
3.	Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүүхдэд хүчирхийлэл үйлддэг ☐ үл хайхардаг ☐ бие махбодын хүчирхийлэл үйлддэг ☐ сэтгэл санааны хүчирхийлэл үйлддэг ☐ бэлгийн хүчирхийлэл, бэлгийн дарамт үзүүлдэг	[ ]	[ ]	
4.	Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүүхдийн дэргэд архидан согтуурдаг	[ ]	[ ]	
5.	Хүүхдийн ашиглаж буй ухаалаг төхөөрөмжийн эцэг эхийн хяналтын горимыг идэвхжүүлэх, хүүхдийн насны онцлогт тохирсон хязгаарлалт тогтоогоогүй/мэдээлэлгүй	[ ]	[ ]	
6.	Өөрийгөө хянах чадваргүй, сэтгэцийн хурц өвчтэй хүн гэр бүлд нь амьдардаг			
7.	Хүүхдээр хөдөлмөр эрхлүүлдэг	[ ]	[ ]	
8.	Гэрийн орчинд хүүхдийн ашиглаж буй интернэтийг 18+ контентын шүүлтүүртэй байхаар тохиргоог идэвхжүүлээгүй	[ ]	[ ]	
9.	Хүүхдийнхээ ашиглаж буй үүрэн холбооны дугаарыг хүүхдийн овог, нэр, иргэний бүртгэлийн дугаар болон хууль ёсны төлөөлөгч /эцэг, эх, асран хамгаалагч/-ийн овог, нэр, иргэний бүртгэлийн дугаарын хамт үнэн зөвөөр бүртгүүлэн, хэрэглээнд хяналт тавиагүй/мэдээлэлгүй	[ ]	[ ]	

Эрсдэлийн үнэлгээ: Хүүхэд хамгааллын эрсдэлийн асуумжийн 1-2 асуултад “тийм” гэж хариулсан бол эрсдэлтэй гэж үзнэ.

Тайлбар:

1. Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 22.3[2]-т заасны дагуу гэрийн орчны эрсдэлийн үнэлгээг энэхүү

[2] Хүүхэд хамгааллын тухай хуулийн 22.3-т “Эцэг, эх хүүхдийн амьдарч байгаа орчны эрсдэлийн үнэлгээг хийж, эрсдэлийг арилгах, гэр бүлийн хүрээнд хүүхдэд аюултай орчин бүрдүүлнэ.”

хяналтын хуудсаар хийж, эрсдэлийг арилгана. Шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллага, мэргэжилтнээс зөвлөгөө авч болно.

2. Нийгмийн ажилтан Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн хүүхэд хамгааллын дуудлагын дагуу, эсхүл Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээний хүрээнд, мөн хүүхэд хамгааллын эргэн хяналт тавих үед энэхүү хяналтын хуудсаар гэр бүлийн орчны үнэлгээг хийнэ. Эрсдэл дунд болон их эрсдэлтэй бол хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлнэ.
3. Хүүхдийн эрхийн улсын байцаагч гэр бүлийн орчинд эрсдэл, зөрчил давтагдсан, хүүхэд эрсдэлд орсон тохиолдолд дараагийн шатны арга хэмжээг авч зөрчлийг арилгуулна.

Г. Баталгаажуулалт

Хэрэв гэр бүлийн орчинд нийгмийн ажилтан эсхүл улсын байцаагч эрсдэлийн үнэлгээ хийсэн тохиолдолд “баталгаажуулалт”-ын хэсгийг нөхөж бичнэ.

МЭРГЭЖИЛТНИЙ БАТАЛГААЖУУЛАЛТ:	
Үнэлгээ хийсэн: *Хяналтын хорооны гишүүн:*	*Хүлээн зөвшөөрсөн:* *Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч:*
.... */овог нэр/*	.... */овог нэр/*
/гарын үсэг, тэмдэг/	*/гарын үсэг/*

УЛСЫН БАЙЦААГЧИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ:	
Шалгалт хийсэн: *Улсын байцаагч:*	*Хүлээн зөвшөөрсөн:* *Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзган дэмжигч:*
.... */овог нэр/*	.... */овог нэр/*
/гарын үсэг, тэмдэг/	*/гарын үсэг/*

Арга хэмжээ авч хэрэгжүүлсэн талаарх мэдээлэл:

Оноо	Үнэлгээ	Тухайн аж ахуй нэгж, байгууллагад авах арга хэмжээ	Биелэлт
		Эрсдэлийг арилгах хугацаатай албан даалгавар	
		Зөвлөмж	

---oOo---

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгаллын сайдын 2026 оны 9 дугаар сарын 15-ны өдрийн А/176 тоот тушаалын дөрөвдүгээр хавсралт

БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ОРЧНЫ ЭРСДЭЛИЙГ ҮНЭЛЭХ ХЯНАЛТЫН ХУУДАС

А. Ерөнхий мэдээлэл

Хуулийн этгээдийн нэр, РД: .....
Үйл ажиллагааны чиглэл: .....
Хаяг, байршил: .....
Огноо: .....

Б. Орчны аюулгүй байдлын эрсдэл

№	Үнэлэх шалгуур үзүүлэлт	**Тийм** *(1)*	**Үгүй** *(0)*	Илэрсэн эрсдэл/Тайлбар
1.	Дотоод/гадаад орчинд ухсан нүх, суваг, шуудуу, траншей, цооног, ил цахилгааны утас, монтажийг засварлаагүй, аюултай	[ ]	[ ]	
2.	Өндөр хүчдэл, цахилгаан тоноглолд ойрхон	[ ]	[ ]	
3.	Газардуулга, хамгаалалтын төхөөрөмжийн доголдолтой	[ ]	[ ]	
4.	Гал унтраагуур, галын дохиололгүй/ажилладаггүй, галын гарц, схемгүй, аврах зам хаалттай, анхааруулга, дохио санамжгүй	[ ]	[ ]	
5.	Шат, цонхны хаалт, хамгаалалт байхгүй, санамж байршуулаагүй, хүүхэд өндрөөс унах эрсдэлтэй	[ ]	[ ]	
6.	Ариун цэврийн байгууламжийн шаардлага хангагдаагүй гадаа орчинд	[ ]	[ ]	
7.	Хүүхдийн тоглоом хэрэгсэл, тоглоомын талбайн аюулгүй байдлыг шалгаж, эрсдэлийг арилгаагүй	[ ]	[ ]	
8.	Гар угаах, ариутгах нөхцөл дутмаг	[ ]	[ ]	
9.	Хог хаягдал, бохирдол ихтэй	[ ]	[ ]	
10.	Орчны гэрэлтүүлэг хангалтгүй, харанхуй	[ ]	[ ]	
11.	Явган зам, гарц эвдрэлтэй, тэмдэг тэмдэглэгээгүй, авто замтай ойр байрладаг	[ ]	[ ]	
12.	Шатахуун түгээх станцтай ойрхон байрладаг	[ ]	[ ]	
13.	Цахилгаан, цэвэр усны хангамж байхгүй	[ ]	[ ]	
14.	Ахуйн химийн бодис, эм эмийн хэрэгслийг цоожилж хадгалаагүй	[ ]	[ ]	
15.	Барилгын орц гарц нь босгогүй, үүдний хэсэгт халтиргаа, гулгаа үүсэхээс хамгаалсан шалавч, цардсан зам, тэргэнцрийн зориулалтын зам байхгүй	[ ]	[ ]	

16.	Дотуур байрны гадна орчин бүрэн камергүй, камерын бичлэгийг 30 ба түүнээс дээш хоног хадгалдаггүй	[ ]	[ ]	
17.	Хоолны хордлого гарах эрсдэлтэй	[ ]	[ ]	
18.	Ундны усны чанар муу	[ ]	[ ]	
19.	Халдварт өвчин тархах эрсдэлтэй	[ ]	[ ]	
	Дүн			

Эрсдэлийн үнэлгээ: [>=50%] Их, [30%-49%] Дунд, [<=29%] Бага эрсдэлтэй гэж үзнэ.

Тайлбар: Хоолны хордлого гарах, ундны усны чанар муу байх, халдварт өвчин тархах эрсдэлийг ажиглалтаар үнэлэхдээ "Эрсдэлийн үнэлгээ хийх заавар"-ыг уншиж, ашиглаарай.

В. Хүүхэд хамгааллын эрсдэл

№	Үнэлэх шалгуур үзүүлэлт	**Тийм** *(1)*	**Үгүй** *(0)*	Илэрсэн эрсдэл/Тайлбар
1.	Боловсролын сургалтын байгууллагад хүүхдийн эсрэг хүчирхийлэл гарах эрсдэлтэй/гарсан ☐ Үе тэнгийн дээрэлхэлт, гадуурхалт гардаг эсэх ☐ хүүхдийг үл хайхрах ☐ бие махбодын хүчирхийлэл ☐ сэтгэл санааны хүчирхийлэл ☐ бэлгийн хүчирхийлэл, бэлгийн дарамт	[ ]	[ ]	
2.	Багш, сурган хүмүүжүүлэгч хүүхдийг хараа хяналтгүй орхидог	[ ]	[ ]	
3.	Хүүхдийг ялгаварлан гадуурхдаг	[ ]	[ ]	
4.	Хүүхэд хамгааллын бодлого баталж, мөрдөөгүй	[ ]	[ ]	
5.	"Эрсдэлийн хяналтын хороо"-гүй	[ ]	[ ]	
6.	Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдийг таних, илрүүлэх, мэдээлэх заавар, журам мөрдөж ажилладаггүй	[ ]	[ ]	
7.	Тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн үйлчилгээний хүртээмж хангалтгүй	[ ]	[ ]	
8.	Хөдөлмөр эрхэлдэг хүүхдийн судалгаа гаргаж, хяналт тавьдаггүй	[ ]	[ ]	
9.	Боловсролын байгууллагад аюулгүй байдлын эрсдэлийг мэдээлэх, санал гаргах "Нээлттэй суваг" (Санал, гомдлын хайрцаг, цахим чатбот, постын суваг) тогтмол ажилладаггүй	[ ]	[ ]	
10.	Хүүхдийн тусламжийн 108 утасны мэдээлэл, санамж сурталчилгааг ил харагдах орчинд байршуулж, сурагчдад мэдээлэл өгдөггүй	[ ]	[ ]	
11.	Цахим орчны аюулгүй байдал, үе тэнгийн дээрэлхэлт (cyberbullying)-ээс урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн ажлыг сурагчид, эцэг эхчүүдэд зохион байгуулдаггүй	[ ]	[ ]	
12.	Багш, ажилтнууд болон сурагчид сургуулийн орчинд цахим хэрэгслийн зохистой хэрэглээний дотоод журмыг мөрдөж хэвшээгүй	[ ]	[ ]	

13.	Сургуулийн Wi-Fi болон цахим сүлжээнд хүүхдийн насны ангилалд (18+) тохиргоогүй, хориотой контент руу нэвтрэхээс хамгаалсан шүүлтүүр (content filtering) идэвхжүүлж, хяналт тавиагүй	[ ]	[ ]	
14.	E-Mongolia болон Ekids аппликейшнээр дамжуулан орчны эрсдэл, зөрчлийг мэдээлэх боломжийг бүрдүүлж, хэрэглээг сурталчилдаггүй	[ ]	[ ]	

Эрсдэлийн үнэлгээ: Хүүхэд хамгаалллын эрсдэлийн асуумжийн 1-2 асуултад “тийм” гэж хариулсан бол эрсдэлтэй гэж үзнэ.

Хүүхэд хамгаалллын тухай хуульд заасны дагуу хүүхэд хамгаалллын үйлчилгээг төлөвлөн хэрэгжүүлнэ.

Г. Баталгаажуулалт

ХЯНАЛТЫН ХОРООНЫ ҮНЭЛГЭЭНИЙ БАТАЛГААЖУУЛАЛТ:	
Үнэлгээ хийсэн: *Хяналтын хорооны гишүүн:*	*Хүлээн зөвшөөрсөн:* *Байгууллагын албан тушаалтан:*
.... */овог нэр/*	.... */ албан тушаалын нэр, овог нэр/*
/гарын үсэг, тэмдэг/	*/ гарын үсэг/*

Хэрэв боловсролын сургалтын байгууллагын орчинд улсын байцаагч эрсдэлийн үнэлгээ хийсэн тохиолдолд “Улсын байцаагчийн баталгаажуулалт”-ын хэсгийг нөхөж бичнэ.

УЛСЫН БАЙЦААГЧИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ:	
Шалгалт хийсэн: *Улсын байцаагч:*	*Хүлээн зөвшөөрсөн:* *Байгууллагын албан тушаалтан:*
.... */овог нэр/*	.... */ албан тушаалын нэр, овог нэр/*
/гарын үсэг, тэмдэг/	*/ гарын үсэг/*

Арга хэмжээ авч хэрэгжүүлсэн талаарх мэдээлэл

Оноо	Үнэлгээ	Тухайн аж ахуй нэгж, байгууллагад авах арга хэмжээ	Биелэлт
		Эрсдэлийг арилгах хугацаатай албан даалгавар	
		Зөвлөмж	

---oOo---

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2026 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн А/176 тоот тушаалын тавдугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЧНЫ ЭРСДЭЛИЙГ ҮНЭЛЭХ ХЯНАЛТЫН ХУУДАС

А. Ерөнхий мэдээлэл

Хуулийн этгээдийн нэр, РД: .....
Үйл ажиллагааны чиглэл: .....
Хаяг, байршил: .....
Огноо: .....

Б. Орчны аюулгүй байдлын эрсдэл

№	Үнэлэх шалгуур үзүүлэлт	**Тийм** *(1)*	**Үгүй** *(0)*	Илэрсэн эрсдэл/Тайлбар
1.	Дотоод/гадаад орчинд ухсан нүх, суваг, шуудуу, траншей, цооног, ил цахилгааны утас, монтажийг засварлаагүй, аюултай	[ ]	[ ]	
2.	Газардуулга, хамгаалалтын төхөөрөмжийн доголдолтой	[ ]	[ ]	
3.	Гал унтраагуур, галын дохиололгүй/ажилладаггүй, галын гарц, аврах зам хаалттай	[ ]	[ ]	
4.	Шат, цонхны хаалт, хамгаалалт байхгүй, санамж байршуулаагүй, хүүхэд өндрөөс унах эрсдэлтэй	[ ]	[ ]	
5.	Ариун цэврийн байгууламжийн шаардлага хангагдаагүй	[ ]	[ ]	
6.	Гар угаах, ариутгах нөхцөл дутмаг	[ ]	[ ]	
7.	Хог хаягдал/ ахуйн бохирдол ихтэй	[ ]	[ ]	
8.	Орчны гэрэлтүүлэг хангалтгүй, харанхуй	[ ]	[ ]	
9.	Явган зам, гарц эвдрэлтэй, тэмдэг тэмдэглэгээгүй, авто замтай ойр байрладаг	[ ]	[ ]	
10.	Шатахуун түгээх станцтай ойрхон байрладаг	[ ]	[ ]	
11.	Ялаа, жоом, хулгана зэрэг халдвар тээгч амьтад эмнэлгийн орчинд ажиглагдсан	[ ]	[ ]	
12.	Цахилгаан, цэвэр усны хангамж байхгүй	[ ]	[ ]	
13.	Ахуйн химийн бодис, эмийн эрсдэл их	[ ]	[ ]	
14.	Хоолны хордлого гарах эрсдэлтэй	[ ]	[ ]	
15.	Ундны усны чанар муу	[ ]	[ ]	
16.	Халдварт өвчин тархах эрсдэлтэй	[ ]	[ ]	
	Дүн			

D: 2026 on 09 sar A4

Эрсдэлийн үнэлгээ: [>=50%] Их, [30%-49%] Дунд, [<=29%] Бага эрсдэлтэй гэж үзнэ.

Тайлбар: Тайлбар: Хоолны хордлого гарах, ундны усны чанар муу байх, халдварт өвчин тархах эрсдэлийг ажиглалтаар үнэлэхдээ "Эрсдэлийн үнэлгээ хийх заавар"-ыг уншиж, ашиглаарай.

В. Хүүхэд хамгааллын эрсдэл

№	Үнэлэх шалгуур үзүүлэлт	**Тийм** *(1)*	**Үгүй** *(0)*	Илэрсэн эрсдэл/Тайлбар
1.	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллагад хүүхдийн эсрэг хүчирхийлэл гарах эрсдэлтэй/гарсан ☐ Үе тэнгийн дээрэлхэлт, гадуурхалт гардаг эсэх ☐ хүүхдийг үл хайхрах ☐ бие махбодын хүчирхийлэл ☐ сэтгэл санааны хүчирхийлэл ☐ бэлгийн хүчирхийлэл, бэлгийн дарамт	[ ]	[ ]	
2.	Хүүхдийн эрхийн зөрчил, ялгаварлан гадуурхалт гардаг	[ ]	[ ]	
3.	"Хүүхэд хамгааллын бодлого" баталж мөрдөөгүй	[ ]	[ ]	
4.	"Эрсдэлийн хяналтын хороо" байгуулаагүй	[ ]	[ ]	
5.	Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдийг таних, илрүүлэх, мэдээлэх заавар, журам мөрддөггүй	[ ]	[ ]	
6.	Тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн үйлчилгээний хүртээмж хангалттай биш	[ ]	[ ]	
7.	Хүүхдийн эрх, хамгааллын талаар сургалт, нөлөөллийн ажлыг эмч, ажилтнуудад зохион байгуулдаг эсэх	[ ]	[ ]	
8.	Байгууллагын Wi-Fi болон цахим сүлжээнд хүүхдийн насны ангилалд тохироогүй, хориотой контент руу нэвтрэхээс хамгаалсан шүүлтүүр (content filtering) хийж, хяналт тавьдаггүй	[ ]	[ ]	
9.	E-Mongolia болон Ekids аппликейшнээр дамжуулан орчны эрсдэл, зөрчлийг мэдээлэх боломжийг бүрдүүлж, хэрэглээг сурталчилдаггүй	[ ]	[ ]	

Эрсдэлийн үнэлгээ: Хүүхэд хамгааллын эрсдэлийн асуумжийн 1-2 асуултад "тийм" гэж хариулсан бол эрсдэлтэй гэж үзнэ.

Хүүхэд хамгааллын тухай хуульд заасны дагуу хүүхэд хамгааллын үйлчилгээг төлөвлөн хэрэгжүүлнэ.

Г. Баталгаажуулалт

ХЯНАЛТЫН ХОРООНЫ ҮНЭЛГЭЭНИЙ БАТАЛГААЖУУЛАЛТ:

Үнэлгээ хийсэн: *Хяналтын хорооны гишүүн:*	*Хүлээн зөвшөөрсөн:* *Байгууллагын албан тушаалтан:*
.... */овог нэр/*	.... */ албан тушаалын нэр, овог нэр/*
/гарын үсэг, тэмдэг/	*/ гарын үсэг/*

Хэрэв байгууллагын орчинд улсын байцаагч эрсдэлийн үнэлгээ хийсэн тохиолдолд “Улсын байцаагчийн баталгаажуулалт”-ын хэсгийг нөхөж бичнэ.

УЛСЫН БАЙЦААГЧИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ:	
Шалгалт хийсэн: *Улсын байцаагч:*	*Хүлээн зөвшөөрсөн:* *Байгууллагын албан тушаалтан:*
.... */овог нэр/*	.... */ албан тушаалын нэр, овог нэр/*
/гарын үсэг, тэмдэг/	*/ гарын үсэг/*

Арга хэмжээ авч хэрэгжүүлсэн талаарх мэдээлэл

Оноо	Үнэлгээ	Тухайн аж ахуй нэгж, байгууллагад авах арга хэмжээ	Биелэлт
		Эрсдэлийг арилгах хугацаатай албан даалгавар	
		Зөвлөмж	

---oOo---

D: 2026 on 09 sar A4

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2026 оны 9. дугаар сарын 15-ны өдрийн А/126 тоот тушаалын зургаадугаар хавсралт

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ӨРГӨН НЭВТРҮҮЛЭГ, ЦАХИМ ОРЧНЫ ЭРСДЭЛИЙГ ҮНЭЛЭХ ХЯНАЛТЫН ХУУДАС

А. Ерөнхий мэдээлэл

Хуулийн этгээдийн нэр, РД: .....
Үйл ажиллагааны чиглэл: .....
Хаяг, байршил: .....
Огноо: .....

Б. Орчны аюулгүй байдлын эрсдэл

№	Үнэлэх шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй	Илэрсэн эрсдэл/Тайлбар
